

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	16
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	18
4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/872  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Амгалан дулааны станц ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, худалдан авалтын үйл ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлэх, санхүүгийн программыг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 23-аас 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, гүйцэтгэх захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Мүүрь Аудит ХХК-ийн баталгаажуулах үйлчилгээний ахлах менежер Н.Дагийрагчаа ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Мүүрь Аудит ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02/85 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Амгалан дулааны станц ХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь орчин үеийн дэвшилтэт технологиор эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангахад оршино.

Амгалан дулааны станц ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан эрчим хүчний үйлдвэрлэл эрхлэх
- Хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн нийгмийн даатгалын хувь хэмжээ;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос хөнгөлөх албан татварын хөнгөлөлтийн хэмжээ өөрчлөгдсөн байна.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний 71 дүгээр тоот тогтоолоор Амгалан дулааны станц ХХК-ийн хэлбэрийг 100 хувь төрийн өмчит бие даасан хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Амгалан дулааны станц ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Амгалан дулааны станц ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ERP программ хангамж ашигладаг байна.

Амгалан дулааны станц ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Амгалан дулааны станц ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 36 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт борлуулалтын орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 10,373.6 сая төгрөгөөс тооцон 103.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 197.5 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,166.9 сая төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өглөг, урт хугацаат өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /сая төгрөг/
Мөнгөн хөрөнгө	27.0	44.8	17.8
Авлага	2,873.6	1,772.4	(1,101.2)
Урьдчилгаа	96.5	212.0	115.5
Бараа материал	926.7	1,037.9	111.2
Үндсэн хөрөнгө	115,451.2	109,141.0	6,310.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>119,375.0</b>	<b>112,208.1</b>	<b>7,166.9</b>
Өр төлбөр	4,457.3	3,842.8	(614.5)
Эздийн өмч	114,917.7	108,365.3	(6,552.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>119,375.0</b>	<b>112,208.1</b>	<b>7,166.9</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь тайлант жилийн зээлээрх борлуулалтын авлагын барагдуулалтаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд тухайн онд үүссэн 1,768.8 сая төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах авлага, 0.4 сая төгрөгийн ажиллагсдаас авах авлага, 3.2 сая төгрөгийн татварын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аваарын нөөц болон нүүрсний нөөцийг нэмэгдүүлснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2019 оноос өмнө худалдаж авсан ашиглалтгүй 62.9 сая төгрөгийн бараа материал нь өмнөх онд бэлтгэсэн аваарын нөөцтэй холбоотой байна. Тайлант онд 2,234.8 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Хөрөнгийн өртөг 939.2 сая төгрөгөөр өссөн байхад, хуримтлагдсан элэгдэл 7,348.1 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгө нь 939.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дүнгээр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө өссөн нь хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгийн программ хангамжаар нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь авлага цуглуулалт хугацаандаа хийгдэж байсантай холбоотойгоор харилцагч байгууллагуудын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөрт Хөгжлийн банкны тусламжийн орлогоос үүссэн 1,135.4 сая төгрөгийн өр, хойшлогдсон татварын өр төлбөрөөс үүссэн 904.5 сая төгрөгийн өр төлбөр байна.

Бусад 340.9 сая төгрөгийн өр төлбөрт Хөгжлийн банкны тусламжийн орлогоос богино хугацаат өр төлбөрт шилжүүлсэн дүн, татварын өглөг болон дутуу олгосон цалингийн өглөгүүд байна.

Эздийн өмчийн дүн 108,365.3 сая төгрөг болж 6,552.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар тайлант хугацаанд алдагдал үүссэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 58.9 сая төгрөгийн бичилт нь 60.5 сая төгрөг нь өмнөх оны цахилгааны зардлыг илүү нэхэмжилсэн дүн, 1.6 сая төгрөг нь өмнөх онд дутуу олгосон цалин, тэтгэмжийн тооцооны зөрүүтэй холбоотой байна.

**2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

“Дулааны 4 дүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 29 дугаар тогтоолоор “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2019 оны зорилтот түвшний тодотголыг баталсан байна. Тайлант онд зорилтот түвшнээр 19,505.3 сая төгрөгийн орлоготой, 26,899.7 сая төгрөгийн зардалтай, 7,394.4 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөжээ.

Тайлант онд 19,505.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 19,969.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 429.1 сая төгрөгөөр давсан нь 715.3 мянган Гкал дулааны эрчим хүч түгээх төлөвлөгөөтэй ажилласнаас 729.4 мянган Гкал дулааны эрчим хүч түгээж, түгээлтийн төлөвлөгөөг давуулан гүйцэтгэснээс шалтгаалсан байна. Бусад орлогод харилцах дансны хүүгийн орлого, түрээсийн орлого, үнс борлуулсны орлого, улсын төсвийн санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын тухайн онд ногдох орлого зэрэг багтсан байна. Бусад орлого 34.8 сая төгрөгөөр өссөн нь харилцах дансны хүүгийн орлого нэмэгдсэн болон тайлант оноос үнсний хаягдлыг борлуулдаг болсонтой холбоотой байна.

Нийт 26,899.7 сая төгрөгийн зардлын зорилтот түвшин батлагдсанаас 3,731.0 сая төгрөгийг цалингийн зардалд, 1,367.0 сая төгрөгийг их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зардалд, 21,801.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Түлшний зардал 124.3 сая төгрөгөөр хэтэрсэн нь 2019 оны дулааны эрчим хүч түгээлтийг төлөвлөгөөнөөс 14.1 мянган Гкал-аар илүү үйлдвэрлэж түгээсэн, шатахууны зардал 59.8 сая төгрөгөөр дутуу байгаа нь бульдозер, ковш зэрэг механизмууд төлөвлөснөөс бага м/цаг ажилласантай холбоотой байна.

Сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардал төлөвлөснөөс 168.0 сая төгрөгөөр дутуу байгаа нь тайлант хугацаанд аваарын нөөц бүрдүүлж урсгал засварт шаардлагатай сэлбэг хэрэгсэл, бараа материалыг бага хэмжээгээр худалдан авч зарцуулсантай холбоотой байна.

Цахилгааны зардал 192.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь 110/10 кВт-ын дэд станцын бэлтгэлд байгаа трансформаторыг 2,3 дугаар саруудад зогсоосонтой, усны зардал 83.3 сая төгрөгөөр дутуу нь Ус сувгийн удирдах газраас нэмэлтээр ус авахаар төлөвлөсөн байсныг худгийн усны хэрэглээгээр зохицуулсантай холбоотой байна.

Амгалан дулааны станц ХХК 2019 онд алдагдлыг 1,038.9 сая төгрөгөөр бууруулж ажиллажээ.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 36 эрсдэл тодорхойлж нийт 36 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,213.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,091.9 сая төгрөгийн алдааг залруулж, 110.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 11.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

### **1. Санхүүгийн тайланд дараах залруулгуудыг хийлээ. Үүнд.**

- 2019 онд ажил нь дууссан капиталжуулах хөрөнгүүдийг ажил хүлээлцсэн өдрөөр бус хожимдуулж капиталжуулалтыг хийснээс 2.0 сая төгрөгөөр элэгдлийн зардал дутуу тооцоолсон нь НББОУС-16-ын 50-59 дүгээр зүйлтэй нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй;

- Бэлтгэн нийлүүлэгчээс авсан үндсэн хөрөнгийг цаг хугацаанд нь орлогод бүртгээгүй хойшлуулж бүртгэсэнтэй холбоотойгоор 1.2 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцоолсон нь НББОУС-16-ын 50-59 дүгээр зүйлтэй нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй;

- Тээврийн хэрэгслүүдэд хийгдсэн урсгал засвараас тээврийн хэрэгслийг капиталжуулах 12.2 сая төгрөгийн зардлыг тайлант хугацааны урсгал засварын зардлаар тайлагнасан нь НББОУС-16-ын 13-14 дүгээр зүйлтэй нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй;

- Засварын ажил нь бүрэн дуусаагүй ажлыг 72.2 сая төгрөгөөр капиталжуулсан нь НББОУС-16-ын 8-10 дугаар зүйлтэй нийцээгүй, үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй;

- 2018 оны ажилтнуудад олгосон цалинтай чөлөө, тэтгэмжтэй чөлөө олголттой холбоотой 2.7 сая төгрөгийн цалингийн зардал, 0.4 сая төгрөгийн НДШ-ийн зардлыг тайлант оны зардлаар бүртгэсэн нь НББОУС-8-ын 42-47 дугаар зүйлтэй нийцээгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй;

- Засварын зардалд зарцуулсан 4.1 сая төгрөгийн бараа материалын төлбөрийг бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй шалтгаанаар засварын зардалд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1 дүгээр заалттай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй;



- Үндсэн хөрөнгийн элэгдлийг ААНОАТ-ын тухай хуулийн дагуу давтан тооцоолоход санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд 906.0 сая төгрөгөөр татварын элэгдлийн зардлыг илүү тайлагнасан нь НББОУС-12-ын 7-9 дүгээр зүйлтэй нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Хойшлогдсон татварын хөрөнгөнөөс 0.2 сая төгрөгийн хэрэгжилтийг бүртгээгүй нь НББОУС-12-ын 56 дугаар зүйлтэй нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Санхүүгийн зорилгоор байгуулсан элэгдэл болон татварын зорилгоор байгуулсан элэгдэл 2-ын зөрүүгээр хойшлогдсон татвар хөрөнгийг 34.4 сая төгрөгөөр дутуу, хойшлогдсон татварын өр төлбөрийг 56.5 сая төгрөгөөр илүү бүртгэсэн нь НББОУС-12-ын 51-52 дугаар зүйлтэй нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй алдаанууд байна.

2. Монгол хьондай автомотив ХХК-ийг суудлын автомашин нийлүүлэх тендерт гүйцэтгэгчээр сонгосон байна. Тендер захиалагч, тендер гүйцэтгэгч нар худалдах худалдан авах гэрээг байгуулахаас өмнө тендерийн баталгааны хугацаа дууссан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д “Захиалагч «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулсны дараа тендерийн баталгааг хүчингүй болгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Монрубин ХХК-тай 17.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тавилга эд хогшил нийлүүлэх тендерт 18.9 төгрөгөөр шууд гэрээ байгуулсан байна. Гэрээний нэмэлт дүн нь тендерийн төсөвт өртгийн 5%-аас хэтэрсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д “Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн” болон 30.2-д “Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс хэтэрсэн тохиолдолд захиалагч 5 хүртэлх хувиар хэтэрсэн үнэтэй тендер ирүүлсэн тендер оролцогчтой гэрээний үнийг төсөвт өртөгт багтаах зорилгоор хэлэлцээ хийх бөгөөд ийнхүү хэлэлцээ хийхдээ захиалагч тендер оролцогчийн санал болгосон үнийг үндэслэлгүйгээр бууруулахыг шаардахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. 45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТУСП Сэлбэг хэрэгсэл нийлүүлэх тендерийн гүйцэтгэгч Хүчит Хөтлүүр ХХК бараа материал нийлүүлэх гэрээгээ цуцлах хүсэлт гаргасан тул шууд гэрээг Энитайм И Гурав ХХК -тай байгуулсан байна. Мөн 18.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын материал, түүний дагалдах хэрэгсэл нийлүүлэх тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулах аргыг сонгож Алво ХХК-ийг тендер гүйцэтгэгчээр сонгохдоо бусад компанийн үнийн саналтай харьцуулалт хийгээгүй сонгосон байна. Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3-д “Энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах” болон 34 дүгээр зүйлийн 34.1.1-д “Энэ хуулийн 30.4.3, 36.18-д заасан тохиолдолд” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

6. 15.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Багаж нийлүүлэх, 12.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сэлбэг хэрэгслийн худалдан авалтад тендерийн харьцуулалтын арга ашиглалгүй шууд гэрээ байгуулах аргыг ашиглаж худалдан авалтуудыг хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “ харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 33 дугаар зүйлийн 33.1-д “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 11.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Худалдан авалтын үйл ажиллагаанаас гарах алдаа зөрчлийн нөлөөллийг санхүүгийн тайланд хэрхэн нөлөөлж байгааг хэмжих боломжгүй байна. Иймд дараагийн жилд худалдан авалтын үйл ажиллагаанд үнэлэлт хийж санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөг авч үзэх хэрэгтэй байна.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Амгалан дулааны станц ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 32 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн, нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 121.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 197.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага гэж үнэлж зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Амгалан дулааны станц ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Санхүүгийн программтай холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээрх үндсэн хөрөнгийн өртөг болон хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдлийг гүйлгээ балансын эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад цех, хэсэг, хэлтэс, албаны үндсэн хөрөнгийн өртөг, хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” мөн Сангийн сайдын 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралттай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Гүйлгээ балансын үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл нь өмнөх оны гүйлгээ балансын эцсийн үлдэгдлээс үндсэн хөрөнгийн анхны өртөг, хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” мөн Сангийн сайдын 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралттай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Журнал, ерөнхий данс, үндсэн хөрөнгийн товчоо тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгын үндсэн хөрөнгийн мэдээлэл буруу тайлагнагдах;

Санхүүгийн тайлан хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүргэх.

### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалт болон Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг мөрдөж ажиллах, санхүүгийн программын хөгжүүлэлт, сайжруулалтыг хийлгэх.

### 3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид санхүүгийн программд зөрүү үүсэхгүй байх талаар сайжруулалт хийлгэхээр төлөвлөж байна.

## 3.2. **Бараа материалтай холбоотой асуудал**

### 3.2.1. Илрүүлэлт

- Монгол Улсын Засгийн Газрын 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Түүхий нүүрсний тээвэрлэлт, хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамжийн хэрэгжилтийн дагуу хураагдаж, үйлчлүүлэгчийн хашаанд буулгагдсан гэх ойролцоогоор 199.5 тонн нүүрсийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тухайн станцыг барьж ашиглалтад өгсөн БНХАУ-ын Машин инженерийн компанийн баталгаат хугацаа 2019 оны 07 дугаар сарын 26-нд дууссантай холбоотой гүйцэтгэгч байгууллагын үлдээсэн 248 нэр төрлийн 5,998 ширхэг бараа материал бүртгэлд тусгагдаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2.2. Эрсдэл:

Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгө, өмч, тайлант хугацааны үйл ажиллагааны зардал, бусад орлого дутуу илэрхийлэгдэх.

### 3.2.3. Өгсөн зөвлөмж:

- Хураагдсан түүхий нүүрсний чанар тухайн дулааны станцын хэрэгцээнд тохирч байгаа тохиолдолд холбогдох байгууллагаас нэгжийн үнэлгээг авч бараа материалд бүртгэх шаардлагатай ба хэрэв түүхий нүүрсний чанар хэрэгцээнд тохирохгүй тохиолдолд холбогдох болон дээд байгууллагаас цаашид ямар арга хэмжээ авах талаар шийдвэр гаргуулах.
- Үнэ төлбөргүй бараа материалын хувьд дээд байгууллагаас шийдвэр гаргуулж дулааны станцын үйл ажиллагаанд ашиглагдаж болохуйц бараа материалыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх.

### 3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйл ажиллагаандаа зөвлөмжийг дагаж ажиллах болно.

## 3.3. **Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

### 3.3.1. Илрүүлэлт:

- Нягтлан бодох бүртгэлд тусгагдаагүй газар чөлөөлөлттэй хамааралтай гэх 4 ш хуучин барилга байгууламж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 2013 онд газар чөлөөлөлтийн ажил гүйцэтгэж байсан Пегасус Сапплайн ХХК-аас Амгалан Дулааны Станцын Ашиглалтын Өмнөх Захиргаанд хүлээлгэн өгсөн өртөгтэй сандвичэн байрыг ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Захиалагч, өмчлөгч, эзэмшигч, үнэлгээ нь тодорхойгүй Интернэшнл повер ХХК-ийн боловсруулсан Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх 50МВт-аар өргөтгөх ТЭЗҮ байна. ТЭЗҮ-ийг боловсруулах талаар тухайн компанитай харилцан байгуулсан гэрээ байхгүй. Ямар нэгэн төлбөр тооцоо төлөгдөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.3.2. Эрсдэл:**

Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгө, өмч, тайлант хугацааны үйл ажиллагааны зардал дутуу илэрхийлэгдэх;

Бүртгэлгүй хөрөнгө байх нь хөрөнгө шамшигдах эрсдэлтэй.

### **3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх 50 МВт-аар өргөтгөх ТЭЗҮ-ийг дээд байгууллагаар шийдвэр гаргуулж нягтлан бодох бүртгэлд бүртгэх.

### **3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Цаашид тухайн станцын хашаанд үнсний хаягдал хийх агуулах болон станцын өргөтгөлийн барилга баригдах тул газар чөлөөлөлтөөр дээрх барилгууд нураагдах тул нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.

Шүүхийн шийдвэрээр дээрх хөрөнгийг тус компанийн өмчид хамааралгүй гэж шийдвэрлэсэн тул хөрөнгийг бүртгэлд тусгаагүй.

## **3.4. Худалдан авалттай холбоотой асуудал**

### **3.4.1.1. Илрүүлэлт:**

Хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хэрэгжилтийг шалгахад батлагдсан зардлын төсөв хэтрээгүй боловч батлагдсан гэрээний үнийн дүнгээс 8.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй байна.

### **3.4.1.2. Эрсдэл:**

Тайлант хугацааны үйл ажиллагааны зардал илүү илэрхийлэгдэх, төсөв хэтрэх.

#### 3.4.1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг худалдан авалтын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

#### 3.4.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Цаашид дээрх зөвлөмжийг худалдан авалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах болно.

#### 3.4.2.1. Илрүүлэлт:

Тухайн жилийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бараа болон ажлыг төлөвлөхөд хэлтэс, тасгууд өөрсдийн гаргасан захиалгыг хайнга, үндэслэл муутай хийдэг нь тухайн жилийн худалдан авалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, байгууллагын үргүй зардлыг нэмэгдүүлэх үндэслэл болж байна.

Худалдан авалтын алба нь тендерийн техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа бусад тасаг, цех, хэлтсүүдтэй хоорондоо уялдаа холбоогүй ажилласнаас худалдан авалтын арга, хэлбэр, худалдан авах зүйлийн нэр төрөл өөрчлөгдөх шалтгаан болж байна.

Захиалагч болон бэлтгэн нийлүүлэгч нарын хооронд байгуулж байгаа гэрээнд талуудын эрх, үүрэг хариуцлага болон гэрээний нөхцөлүүдийг оновчтой тодорхойлоогүйгээс ирээдүйд зарга маргаан үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

Дээрх нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-д “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх болон эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### 3.4.2.2. Эрсдэл:

Тендерийн үйл ажиллагааны процесс буруу хийгдэх, тендер хүчингүй болох, тендерийн үйл ажиллагаанаас хамааралтай зарга маргаан үүсэх эрсдэлтэй.

#### 3.4.2.3. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө оруулалтаар хийгдэх бараа ажил үйлчилгээг үндэслэлтэй төлөвлөх, хэлтэс, тасаг, цех хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, худалдан авалтын гэрээний төслийг сайжруулах.

#### 3.4.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

### **3.5. Зардалтай холбоотой асуудал**

#### 3.5.1. Илрүүлэлт:

Буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас шүүхийн шийдвэрээр тухайн байгууллагын ажилтанд 3.5 сая төгрөгийн цалин нөхөн олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.5.2. Эрсдэл:

Тайлант хугацааны үйл ажиллагааны зардал илүү илэрхийлэгдэх, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах;

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн харилцааг хуульд нийцүүлж байх, ажлаас чөлөөлөх үндэслэлийг зөв төлөвлөж, баримт бичигт тусгах үүнтэй холбоотой дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	27,046,350.72	44,819,291.43
1.1.2	Дансны авлага	2,873,531,628.85	1,768,749,902.46
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	40,845.28	3,182,539.84
1.1.4	Бусад авлага	50,000.00	410,388.10
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	926,647,390.61	1,037,881,666.09
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	96,501,610.46	212,034,948.41
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>3,923,817,825.92</b>	<b>3,067,078,736.33</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	102,102,761,634.72	95,700,153,108.85
1.2.2	Биет бус хөрөнгө	13,106,421,742.16	13,100,201,579.75
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	242,007,860.12	340,642,513.57
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>115,451,191,237.00</b>	<b>109,140,997,202.17</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>119,375,009,062.92</b>	<b>112,208,075,938.50</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	2,068,108,940.72	1,462,080,339.47
2.1.1.2	Цалингийн өглөг	1,569,030.67	2,097,322.90
2.1.1.3	Татварын өр	446,006,664.74	213,721,855.08
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	104,178,370.78	125,070,350.46
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			



	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,619,863,006.91</b>	<b>1,802,969,867.91</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	556,040,309.16	904,511,275.72
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,281,404,609.48	1,135,344,502.01
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,837,444,918.64</b>	<b>2,039,855,777.73</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>4,457,307,925.55</b>	<b>3,842,825,645.64</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	109,934,367,286.40	109,934,367,286.40
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,496,116,697.19	2,496,116,697.19
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	13,005,849,600.00	13,005,849,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(10,518,632,446.22)	(17,071,083,290.73)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>114,917,701,137.37</b>	<b>108,365,250,292.86</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>119,375,009,062.92</b>	<b>112,208,075,938.50</b>

## 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>17,836,432,786.80</b>	<b>19,753,810,133.50</b>
2	Борлуулалтын өртөг	(22,146,564,606.17)	(24,098,985,714.54)
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(4,310,131,819.37)</b>	<b>(4,345,175,581.04)</b>
4	Түрээсийн орлого	9,450,000.00	3,773,000.00
5	Хүүгийн орлого	14,100,069.19	59,202,801.14
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	96,419,341.21	152,393,970.13
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(1,736,717,964.76)	(1,960,702,855.16)
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	(106,204,756.88)	(265,021,063.66)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(18,877.00)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)	(26,573,350.60)	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(6,059,658,481.21)</b>	<b>(6,355,548,605.59)</b>
19	Орлогын татварын зардал	(263,727,055.45)	(255,756,593.22)
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(6,323,385,536.66)</b>	<b>(6,611,305,198.81)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(6,323,385,536.66)</b>	<b>(6,611,305,198.81)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>		
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	109,934,367,286.40			(4,197,459,049.18)	105,736,908,237.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл				2,212,139.62	2,212,139.62
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,323,385,536.66)	(6,323,385,536.66)
5	Бусад дэлгэрэнгүй орлого		2,496,116,697.19	13,005,849,600.00		15,501,966,297.19
6	Өмчид гарсан өөрчлөлт					
7	Зарласан ногдол ашиг					
8	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(10,518,632,446.22)	114,917,701,137.37
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
10	Залруулсан үлдэгдэл				58,854,354.30	58,854,354.30
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,611,305,198.81)	(6,611,305,198.81)
12	Бусад дэлгэрэнгүй орлого					
13	Өмчид гарсан өөрчлөлт					
14	Зарласан ногдол ашиг					
15	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
16	2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(17,071,083,290.73)	108,365,250,292.86

#### 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>17,289,360,615.38</b>	<b>22,914,566,186.07</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,760,174,042.36	22,844,872,561.80
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	529,186,573.02	69,693,624.27
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>16,727,278,490.95</b>	<b>21,904,953,849.50</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,820,704,031.31	2,917,822,700.15
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	817,170,333.55	949,150,293.44
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,454,978,526.35	9,143,952,534.49
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,864,944,902.53	4,252,712,835.68
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	72,357,100.00	2,147,626,824.50
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	921,171,286.62	1,593,125,253.56
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	530,550.00	1,387,206.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	775,421,760.59	899,176,201.68
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>562,082,124.43</b>	<b>1,009,612,336.57</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>14,100,069.19</b>	<b>59,202,801.14</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	14,100,069.19	59,202,801.14
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>482,175,131.10</b>	<b>1,051,042,197.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	481,625,131.10	1,051,042,197.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		

2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	550,000.00	
2.2.6			
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(468,075,061.91)</b>	<b>(991,839,395.86)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>30,431,905.05</b>	<b>-</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	30,431,905.05	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>160,247,770.05</b>	<b>-</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	160,247,770.05	
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(129,815,865.00)</b>	<b>-</b>
4	Валютын ханшийн зөрүү	-	-
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(35,808,802.48)</b>	<b>17,772,940.71</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>62,855,153.20</b>	<b>27,046,350.72</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>27,046,350.72</b>	<b>44,819,291.43</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хийсэн аудит</b>	Аудитын код:
2020.03.11			САГ-2020/28/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>“Амгалан дулааны станц” ХХК</b>		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн товчоо тайлангаарх үндсэн хөрөнгийн өртөг болон хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдлийг гүйлгээ балансын эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад цех, хэсэг, хэлтэс, албаны үндсэн хөрөнгийн өртөг, хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч	Ө.Удвал
2	Гүйлгээ балансын үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл нь өмнөх оны гүйлгээ балансын эцсийн үлдэгдлээс үндсэн хөрөнгийн анхны өртөг, хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч	Ө.Удвал
3	МУ-ын ЗГ-ын 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Түүхий нүүрсний тээвэрлэлт, хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамжийн хэрэгжилтийн дагуу хураагдсан 199.5 тн нүүрсийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч	Ө.Удвал
4	Тухайн станцыг барьж ашиглалтад өгсөн БНХАУ-ын Машин инженерийн компанийн баталгаат хугацаа 2019 оны 07 дугаар сарын 26-нд дууссантай холбоотой гүйцэтгэгч байгууллагын үлдээсэн 248 нэр төрлийн 5,998 ширхэг бараа материал бүртгэлд тусгагдаагүй байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч	Ө.Удвал
5	Нягтлан бодох бүртгэлд тусгагдаагүй газар чөлөөлөлттэй хамааралтай 4 ш хуучин барилга байгууламж байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч	Ө.Удвал
6	2013 онд газар чөлөөлөлтийн ажил гүйцэтгэж байсан Пегасус Сапплайн ХХК-аас Амгалан Дулааны Станц Ашиглалтын Өмнөх Захиргаанд		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн	Ө.Удвал

	хүлээлгэн өгсөн сендвичэн байрыг ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн байна.			түр орлон гүйцэтгэгч	
7	Интернэшнл повер ХХК нь Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх 50МВт-аар өргөтгөх ТЭЗҮ боловсруулан тус байгууллагад хүлээлгэн өгсөн байна. ТЭЗҮ-ийг боловсруулах талаар тухайн компанитай харилцан байгуулсан гэрээ байхгүй. Ямар нэгэн төлбөр тооцоо төлөгдөөгүй байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч	Ө.Удвал
8	Хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хэрэгжилтийг шалгахад батлагдсан гэрээний үнийн дүнгээс 8.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.	8.2	Зөвлөмж өгөх	ААХА-ны дарга	Г.Амарбаяс галан
9	Тухайн жилийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бараа болон ажлыг төлөвлөхөд хэлтэс, тасгууд өөрсдийн гаргасан захиалгыг хайнга, үндэслэл муутай хийдэг нь тухайн жилийн худалдан авалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, байгууллагын үргүй зардлыг нэмэгдүүлэх үндэслэл болж байна. Худалдан авалтын алба нь тендерийн техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа бусад тасаг, цех, хэлтсүүдтэй хоорондоо уялдаа холбоогүй ажилласнаас худалдан авалтын арга, хэлбэр, худалдан авах зүйлийн нэр төрөл өөрчлөгдөх шалтгаан болж байна. Захиалагч болон бэлтгэн нийлүүлэгч нарын хооронд байгуулж байгаа гэрээнд талуудын эрх, үүрэг хариуцлага болон гэрээний нөхцөлүүдийг оновчтой тодорхойлоогүйгээс ирээдүйд зарга маргаан үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.		Зөвлөмж өгөх	ААХА-ны дарга	Г.Амарбаяс галан
10	Буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас шүүхийн шийдвэрээр тухайн байгууллагын ажилтанд 3.5 сая төгрөгийн цалин нөхөн олгосон	3.5	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч	Ө.Удвал
11	Монгол хьондай автомотив ХХК-ийг суудлын автомашин нийлүүлэх тендерт гүйцэтгэгчээр сонгосон байна. Тендер захиалагч, тендер гүйцэтгэгч нар худалдах худалдан авах гэрээг байгуулахаас өмнө тендерийн баталгааны хугацаа дууссан байна.		Албан шаардлага хүргүүлэх	ААХА-ны дарга	Г.Амарбаяс галан

12	17.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тавилга эд хогшил нийлүүлэх тендерийн гүйцэтгэгч Монрубин ХХК - тай 18.9 төгрөгөөр шууд гэрээ байгуулсан байна. Гэрээний нэмэлт дүн нь тендерийн төсөвт өртгийн 5%-аас хэтэрсэн байна.	17.2	Албан шаардлага хүргүүлэх	ААХА-ны дарга	Г.Амарбаяс галан
13	45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТУСП Сэлбэг хэрэгсэл нийлүүлэх тендерийн гүйцэтгэгч Хүчит Хөтлүүр ХХК бараа материал нийлүүлэх гэрээгээ цуцлах хүсэлт гаргасан тул шууд гэрээг Энитайм И Гурав ХХК - тай байгуулсан байна. Мөн 18.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын материал, түүний дагалдах хэрэгсэл нийлүүлэх тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулах аргыг сонгож Алво ХХК-ийг тендер гүйцэтгэгчээр сонгохдоо бусад компанийн үнийн саналтай харьцуулалт хийгээгүй сонгосон байна.	64.4	Албан шаардлага хүргүүлэх	ААХА-ны дарга	Г.Амарбаяс галан
14	15.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Багаж нийлүүлэх, 12.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сэлбэг хэрэгслийн худалдан авалтад тендерийн харьцуулалтын арга ашиглалгүй шууд гэрээ байгуулах аргыг ашиглаж худалдан авалтуудыг хийсэн байна.	28.5	Албан шаардлага хүргүүлэх	ААХА-ны дарга	Г.Амарбаяс галан





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/184

Улаанбаатар хот

САГ- 2020/28/СТА-ТОЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монрубин ХХК-ийг 17.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тавилга эд хогшил нийлүүлэх тендер гүйцэтгэгчээр шалгаруулж гэрээг 18.9 төгрөгөөр байгуулсан байна. Гэрээний нэмэлт дүн нь тендерийн төсөвт өртгийн 5%-аас хэтэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д “Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн” болон 30.2-д “Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс хэтэрсэн тохиолдолд захиалагч 5 хүртэлх хувиар хэтэрсэн үнэтэй тендер ирүүлсэн тендерт оролцогчтой гэрээний үнийг төсөвт өртөгт багтаах зорилгоор хэлэлцээ хийх бөгөөд ийнхүү хэлэлцээ хийхдээ захиалагч тендерт оролцогчийн санал болгосон үнийг үндэслэлгүйгээр бууруулахыг шаардахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
2. Монгол хьюндай автоматив ХХК-ийг суудлын автомашин нийлүүлэх тендер гүйцэтгэгчээр шалгаруулсан байна. Тендер захиалагч, тендер гүйцэтгэгч нар худалдах худалдан авах гэрээг байгуулахаас өмнө тендерийн баталгааны хугацаа дууссан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д “Захиалагч «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулсны дараа тендерийн баталгааг хүчингүй болгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.
3. 45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТУСП Сэлбэг хэрэгсэл нийлүүлэх тендерийн гүйцэтгэгч Хүчит Хөтлүүр ХХК бараа материал нийлүүлэх гэрээгээ цуцлах хүсэлт гаргасан тул шууд гэрээг Энитайм И Гурав ХХК -тай байгуулсан байна. Мөн 18.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын материал, түүний дагалдах хэрэгсэл нийлүүлэх тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулах аргыг сонгож Алво ХХК-ийг тендер гүйцэтгэгчээр сонгохдоо бусад компанийн үнийн саналтай харьцуулалт хийгээгүй сонгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3-д “Энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах” болон 34 дүгээр зүйлийн 34.1.1-д “Энэ хуулийн 30.4.3, 36.18-д заасан тохиолдолд” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10\Bichir\_Kheree\Alban\_Shaardлага\2020\03255AG16.Docx

001080633

4. 15.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Багаж нийлүүлэх, 12.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сэлбэг хэрэгслийн худалдан авалтад тендерийн харьцуулалтын арга ашиглалгүй шууд гэрээ байгуулах аргыг ашиглаж худалдан авалтуудыг хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 33 дугаар зүйлийн 33.1-д “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсөвт өртөгт багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах;
2. Тендерийн баталгааг худалдах, худалдан авах гэрээ байгуулсаны дараа цуцалж байх, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах;
3. Босго үнийн хязгаарыг худалдан авах үйл ажиллагаанд баримтлах, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах;
4. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Амгалан дулааны станц ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх, ерөнхий нягтлан бодогч түр орлогч Ө.Удвал нарт даалгав.

#### АЛБАН ШААРДЛАГЫГ

**ӨГСӨН:**  
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТЫН МЕНЕЖЕР *Ц.Хосжаргал* Ц.ХОСЖАРГАЛ  
**ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:**  
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН БҮАМЕЦЕЖЕР  
*Н.Дагийрагчаа* Н.ДАГИЙРАГЧАА

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
*Ш.Баянмөнх* Ш.БАЯНМӨНХ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН  
ТҮР ОРЛОГЧ *Ө.Удвал* Ө.УДВАЛ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



